**ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Алтай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ХОА-2025/010/НА-СТА-ТШ3

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Ховд хот<br>2025 он | Төрийн аудитын газрын<br>дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар<br>Утас: 70433061 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn<br>Аудитын менежер: А.Цэцэгсүрэн<br>Утас:70432545 Цахим хаяг:tsetsegsurena@audit.gov.mn<br>Аудитор: Д.Энхжаргал<br>Утас:70432545 Цахим хаяг: enkhjargald@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2025. 02.13 № 2/31

танай ____________ -ны № ____________ -т

АЛТАЙ СУМЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Т.ЦЭЦЭГБАДАМ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Алтай сумын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Алтай сумын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 87,000.0 мянган төгрөгийн санхүүжилтээр сургуулийн дотуур байрны засвар, сумын орон нутгийн хөгжлийн сангийн 47,350.0 мянган төгрөгийн санхүүжилтээр спорт заалны шалны засвар хийгдсэн байна.

**Аудитын гол асуудал**

Сургуулийн бүсийг утасгүй интернэтээр хангах, цахим анги байгуулах санхүүгийн түрээсийн гэрээг 161,374.0 мянган төгрөгөөр байгуулсантай холбоотойгоор өглөг өссөн байна.

Тайлант онд улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 247,580.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө хүлээн авсан байна.

**Бусад асуудлын хэсэг**

2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 11 зорилтын хүрээнд 66 арга хэмжээ төлөвлөснөөс гүйцэтгэлийг 90.6 хувийн биелэлтэй гэж дээд шатны төсвийн захирагчаас

дүгнэсэн байна. Гүйцэтгэлийн үнэлгээгээр 1 дүгээр шатанд үнэлэгдэж 36,752.5 мянган төгрөгийн урамшуулал авсан байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Х.БОЛДБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **205,010,810.77** | **303,332,373.15** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 78,835,240.23 | 137,155,253.69 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 78,835,240.23 | 137,155,253.69 |
| **3121** | **Төгрөг** | 78,835,240.23 | 137,155,253.69 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 78,835,240.23 | 137,155,253.69 |
| **33** | **АВЛАГА** | 11,810,612.93 | 11,810,612.93 |
| **335** | **Бусад авлага** | 11,810,612.93 | 11,810,612.93 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 11,810,612.93 | 11,810,612.93 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 114,364,957.61 | 154,366,506.53 |
| **351** | **Түүхий эд материал** | 00.00 | 799,650.00 |
| 35130 | Эм боох материал | 00.00 | 799,650.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 114,364,957.61 | 153,566,856.53 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 5,390,800.00 | 5,827,500.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 64,290,100.28 | 54,067,033.20 |
| 35450 | Барилгын засварын материал | 3,010,000.00 | 3,010,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 20,725,243.50 | 27,149,292.50 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 20,948,813.83 | 63,513,030.83 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **5,323,474,943.06** | **5,658,623,712.12** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 5,323,474,943.06 | 5,658,623,712.12 |
| **392** | **Биет хөрөнгө** | 5,298,274,943.10 | 5,634,523,712.20 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 4,997,863,488.93 | 5,132,213,488.93 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -347,675,715.84 | -435,161,451.12 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 349,351,543.00 | 612,275,094.80 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -199,171,929.40 | -227,059,580.80 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 274,376,518.60 | 354,256,018.90 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -133,670,418.92 | -153,009,020.52 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 330,226,768.00 | 330,226,768.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -21,254,896.56 | -27,447,191.28 |
| 39217 | Ном | 48,229,585.29 | 48,229,585.29 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 25,199,999.96 | 24,099,999.92 |
| 39301 | Програм хангамж | 7,304,000.00 | 7,304,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -2,104,000.04 | -3,204,000.08 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 20,000,000.00 | 20,000,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **5,528,485,753.83** | **5,961,956,085.27** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **2,820,582.51** | **170,059,675.87** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 2,820,582.51 | 170,059,675.87 |
| **413** | **Өглөг** | 2,820,582.51 | 170,059,675.87 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 00.00 | 8,665,796.61 |
| **4136** | **Бусад өглөг** | 2,820,582.51 | 161,393,879.26 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 2,820,582.51 | 161,393,879.26 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **5,525,665,171.32** | **5,791,896,409.40** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 5,525,665,171.32 | 5,791,896,409.40 |

| | | | |
|---|---|---|---|
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,910,020,624.00 | 1,910,020,624.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 1,910,020,624.00 | 1,910,020,624.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 2,594,256,840.23 | 2,860,488,078.31 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 2,594,256,840.23 | 2,594,256,840.23 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 266,231,238.08 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,021,387,707.09 | 1,021,387,707.09 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **5,528,485,753.83** | **5,961,956,085.27** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,112,451,752.46** | **3,391,393,048.10** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **43,433,552.46** | **392,543,248.10** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 43,433,552.46 | 350,226,048.10 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 38,827,304.46 | 350,226,048.10 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 42,530,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 38,827,304.46 | 307,696,048.10 |
| **122** | **Тусламжийн орлого** | 00.00 | 42,317,200.00 |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 00.00 | 42,317,200.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,069,018,200.00** | **2,998,849,800.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,727,497,700.00 | 2,551,289,400.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,727,497,700.00 | 2,551,289,400.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 00.00 | 3,372,900.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 3,372,900.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 341,520,500.00 | 444,187,500.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 341,520,500.00 | 444,187,500.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **2,107,393,214.29** | **3,125,161,810.02** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,107,393,214.29** | **3,125,161,810.02** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 2,032,835,936.79 | 2,999,901,541.96 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,204,739,845.59 | 1,888,091,147.24 |
| 210101 | Үндсэн цалин | 1,204,739,845.59 | 1,116,055,536.41 |
| 210102 | Нэмэгдэл | 00.00 | 660,352,494.61 |
| 210104 | Урамшуулал | 00.00 | 111,683,116.22 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 155,284,896.51 | 240,773,056.87 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 104,195,296.51 | 163,750,545.34 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 12,772,500.60 | 19,046,636.77 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 10,217,700.00 | 10,243,521.50 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,554,399.40 | 10,186,382.65 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 25,545,000.00 | 37,545,970.61 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 338,384,400.00 | 421,001,472.44 |

| | | | |
|---|---|---|---|
| 210301 | Гэрэл, цахилгаан | 13,253,200.00 | 17,108,500.00 |
| 210302 | Түлш, халаалт | 299,982,300.00 | 373,001,632.25 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 25,148,900.00 | 30,891,340.19 |
| **2105** | **Нормативт зардал** | 120,082,022.50 | 136,501,423.50 |
| 210502 | Хоол, хүнс | 120,082,022.50 | 136,501,423.50 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 91,000.00 | 2,050,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 91,000.00 | 2,050,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 7,210,680.00 | 52,203,762.79 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 00.00 | 22,403,604.40 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 7,210,680.00 | 29,800,158.39 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 207,043,092.19 | 259,280,679.12 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 65,800,383.25 | 95,225,283.33 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 716,250.00 | 22,051,116.75 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 140,526,458.94 | 142,004,279.04 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 74,557,277.50 | 125,260,268.06 |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | 00.00 | 7,500.00 |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 00.00 | 7,500.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 74,557,277.50 | 105,702,840.50 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 37,378,677.50 | 68,950,040.50 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 37,178,600.00 | 36,752,800.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 00.00 | 19,549,927.56 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 19,549,927.56 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **5,058,538.17** | **266,231,238.08** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **5,058,538.17** | **266,231,238.08** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **2,073,624,448.00** | **3,083,697,000.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **4,606,248.00** | **84,847,200.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 4,606,248.00 | 42,530,000.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 00.00 | 42,530,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 42,530,000.00 |
| 120009 | Бусад орлого | 4,606,248.00 | 00.00 |
| **122** | **Тусламжийн орлого** | 00.00 | 42,317,200.00 |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 00.00 | 42,317,200.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,069,018,200.00** | **2,998,849,800.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,727,497,700.00 | 2,551,289,400.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,727,497,700.00 | 2,551,289,400.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 00.00 | 3,372,900.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 341,520,500.00 | 444,187,500.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 341,520,500.00 | 444,187,500.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **2,031,573,205.77** | **3,025,376,986.54** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,031,573,205.77** | **3,025,376,986.54** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,922,702,075.77** | **2,893,557,458.98** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,216,530,579.26 | 1,888,335,813.68 |
| 210101 | Үндсэн цалин | 799,737,674.71 | 1,116,300,202.85 |
| 210102 | Нэмэгдэл | 368,646,452.98 | 660,352,494.61 |
| 210104 | Урамшуулал | 48,146,451.57 | 111,683,116.22 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 155,284,896.51 | 231,862,593.82 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 104,195,296.51 | 159,490,988.94 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 12,772,500.60 | 17,195,770.28 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 10,217,700.00 | 9,243,521.50 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,554,399.40 | 9,186,382.65 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 25,545,000.00 | 36,745,930.45 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 338,384,400.00 | 421,001,472.44 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 13,253,200.00 | 17,108,500.00 |
| 210302 | Түлш, халаалт | 299,982,300.00 | 373,001,632.25 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 25,148,900.00 | 30,891,340.19 |
| **2105** | **Нормативт зардал** | 87,892,600.00 | 93,388,500.00 |
| 210502 | Хоол, хүнс | 87,892,600.00 | 93,388,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,136,100.00 | 3,636,100.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,136,100.00 | 3,636,100.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 00.00 | 00.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 9,533,000.00 | 60,354,011.39 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 00.00 | 20,541,853.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 9,533,000.00 | 39,812,158.39 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 111,940,500.00 | 194,978,967.65 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 97,641,000.00 | 177,175,567.65 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 14,299,500.00 | 17,803,400.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **108,871,130.00** | **131,819,527.56** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 108,871,130.00 | 112,269,600.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 71,692,530.00 | 75,516,800.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 37,178,600.00 | 36,752,800.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 00.00 | 19,549,927.56 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 19,549,927.56 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **42,051,242.23** | **58,320,013.46** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 42,051,242.23 | 58,320,013.46 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 36,783,998.00 | 78,835,240.23 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 78,835,240.23 | 137,155,253.69 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 1,890,020,624.00 | 5,612,521.00 | -384,935,578.08 | 1,510,697,566.92 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,890,020,624.00** | **5,612,521.00** | **-384,935,578.08** | 1,510,697,566.92 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -7,829,000.80 | -7,829,000.80 |
| C08 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,910,020,624.00** | **1,021,387,707.09** | **2,594,256,840.23** | 5,525,665,171.32 |
| D01 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,910,020,624.00** | **1,021,387,707.09** | **2,594,256,840.23** | 5,525,665,171.32 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,910,020,624.00** | **1,021,387,707.09** | **2,594,256,840.23** | 5,525,665,171.32 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 266,231,238.08 | 266,231,238.08 |
| D09 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,910,020,624.00** | **1,021,387,707.09** | **2,860,488,078.31** | 5,791,896,409.40 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 3,058,189,000.00 | 3,005,827,058.98 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 3,058,189,000.00 | 3,005,827,058.98 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 3,058,189,000.00 | 2,893,557,458.98 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 2,001,790,200.00 | 1,888,335,813.68 |
| 210101 | Үндсэн цалин | 1,247,882,000.00 | 1,116,300,202.85 |
| 210102 | Нэмэгдэл | 660,213,600.00 | 660,352,494.61 |
| 210104 | Урамшуулал | 93,694,600.00 | 111,683,116.22 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 250,223,800.00 | 231,862,593.82 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 170,152,100.00 | 159,490,988.94 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 20,017,900.00 | 17,195,770.28 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 10,009,000.00 | 9,243,521.50 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 10,009,000.00 | 9,186,382.65 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 40,035,800.00 | 36,745,930.45 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 440,551,400.00 | 421,001,472.44 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 17,108,500.00 | 17,108,500.00 |
| 210302 | Түлш, халаалт | 390,196,100.00 | 373,001,632.25 |

| | | | |
|---|---|---|---|
| 210303 | Цэвэр, бохир ус | 33,246,800.00 | 30,891,340.19 |
| **2105** | **Нормативт зардал** | 93,388,500.00 | 93,388,500.00 |
| 210502 | Хоол, хүнс | 93,388,500.00 | 93,388,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,636,100.00 | 3,636,100.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,636,100.00 | 3,636,100.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 62,572,400.00 | 60,354,011.39 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 22,760,200.00 | 20,541,853.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 39,812,200.00 | 39,812,158.39 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 206,026,600.00 | 194,978,967.65 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 188,223,200.00 | 177,175,567.65 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 17,803,400.00 | 17,803,400.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 112,269,600.00 | 112,269,600.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 112,269,600.00 | 112,269,600.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 75,516,800.00 | 75,516,800.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 36,752,800.00 | 36,752,800.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 3,170,458,600.00 | 3,064,147,072.44 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 2,551,289,400.00 | 2,551,289,400.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 2,551,289,400.00 | 2,551,289,400.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 444,187,500.00 | 424,637,572.44 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 444,187,500.00 | 424,637,572.44 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 174,981,700.00 | 45,902,900.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 3,690,300.00 | 3,372,900.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 92,456,200.00 | 42,530,000.00 |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 78,835,200.00 | 00.00 |
| 1200044 | Гадаадын эх үүсвэрээс санхүүжих | 00.00 | 00.00 |
| **122** | **ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ** | 00.00 | 42,317,200.00 |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 00.00 | 42,317,200.00 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 78,835,240.23 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 137,155,253.69 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 01.00 | 01.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 01.00 | 01.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 66.00 | 66.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 36.00 | 36.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 29.00 | 29.00 |
| **63** | **СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)** | 703.00 | 703.00 |
| **630** | **ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД** | 703.00 | 703.00 |
| 630001 | Төрийн өмчит ЕБС | 703.00 | 703.00 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **66.00** | **66.00** |
| 650004 | СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | 66.00 | 66.00 |

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 308,717.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 295,924.0 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа [1] -г аудитын явцад залруулж, баталгаажуулав. Үүнд:

- Хүлээн авсан компьютер тоног төхөөрөмж, хийгдэж дууссан засварын ажлын 295,924.0 мянган төгрөгийн хөрөнгийг дансанд бүртгэлд тусгаагүй

Залруулагдаагүй 12,519.4 мянган төгрөгийн 3 зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 12,519.4 мянган төгрөгийн 3 зөрчил[2] илэрснээс, 10,023.8 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 2,495.6 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

### 5.1 Төлбөрийн акт

5.1.1 *Сургуулийн сургалтын менежер, багш нар, нийгмийн ажилтан, дотуур байрны багш нарт ур чадварын нэмэгдэл олгохдоо ажилтнуудын ур чадварыг ажлын хэсэг байгуулан тусгай шалгуураар үнэлж дүгнээгүй, нийтэд нь үндэслэлгүйгээр олгосон 9,383.5 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", БШУС, ХНХС, СС-ын хамтарсан 2021 оны 2 дугаар сарын 01-ны А/35/А10/9/ дугаар тушаалаар баталсан "Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, зарим албан тушаалтанд ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт"-ын холбогдох заалтуудыг зөрчсөн байна.*

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон

5.1.2 *Тайлант онд хэрэглэсэн сүү хөтөлбөрийн хүрээнд хэмнэгдсэн зардлыг төсөвт буцаан төвлөрүүлээгүй 640.3 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2-д "Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ", 45.2.1-д "нэгжид ногдох норм, нормативаар тооцон төсвийг нь баталсан ба гүйцэтгэл нь анх тооцсон нэгжийн тоо хэмжээнээс бага бол", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" заалттай нийцэхгүй байна.*

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон

### 5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 5.2.1 Дотоод хяналттай холбоотой асуудлаар

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] *Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.*

*<u>Илрүүлэлт:</u> Тайлант онд БШУЯ-с ирсэн бусад сурах бичгийг дансанд дутуу бүртгэсэн, сурагчдад тараасан түрээсийн сурах бичгийн тооцоог номын санчтай хийж, авлага өглөгийн тооцоо нийлээгүй, түрээсийн төлбөрийг төвлөрүүлээгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7-т "Тусламж, хандивын орлогыг холбогдох журмын дагуу бүртгэж, гүйцэтгэлийг тайлагнана." Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.5-т "бүх орлого", 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Боловсрол, соёл шинжлэх ухааны сайдын 2019 оны 5 дугаар сарын 14-ний А/302 дугаар тушаалаар баталсан "Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдад сурах бичиг төлбөртэй ашиглуулах журам "-ын холбогдох заалтуудтай нийцээгүй байна.*

*<u>Өгсөн зөвлөмж:</u> Дотоод хяналтыг сайжруулах, бүртгэлд аваагүй сурах бичгийг данс бүртгэлд тусгах, номын санчтай түрээсийн сурах бичгийн тооцоо хийх, түрээсийн төлбөрийг төвлөрүүлэх*

### 5.2.2 Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

*<u>Илрүүлэлт:</u> Газрын нэгдсэн сангийн системд бүртгэлтэй 8408000802 нэгж талбарын дугаар бүхий 1000 м2 газрыг 15 жилийн хугацаатай эзэмшүүлэхээр олгогдож газар эзэмшүүлэх гэрээ хийгдсэн ч газрыг үнэлж данс бүртгэлд тусгаагүй зөрчил илэрсэн нь УСНББОУС-1, УСНББОУС31 Биет бус хөрөнгө АДБОУС 200,2000, MNS-6817-4:2020 стандартын 7.1.1.2.2, 7.1..3.4, 7.1.3.5 заалтууд болон Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны "Журам шинэчлэн батлах тухай" 271 дүгээр тогтоолын 3 дугаар зүйлийн 3.8-д 'Төрийн өмчит хуулийн этгээд нь газар эзэмших эрх шинээр авах саналаа тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулан, холбогдох Газрын алба, сумын газрын даамалд хүсэлт гарган шийдвэрлүүлнэ. Газар эзэмших/ашиглах эрх үүсмэгц түүнийг үнэлж, санхүүгийн тайланд бүртгэх саналыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.*

*<u>Өгсөн зөвлөмж:</u> Газрын нэгдсэн системд бүртгэлтэй газруудыг данс бүртгэлд тусгах арга хэмжээг авч ажиллах*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 05 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### 6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

*/мянган төгрөгөөр/*

| Алдааны утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс: Залруулсан | | Үүнээс: Залруулаагүй | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | тоо | Дүн | тоо | Дүн | Тоо | Дүн |
| 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 |
| Төслийн хөрөнгө оруулалтаар ирсэн тоног төхөөрөмжийг данс бүртгэлд тусгаагүй | 1 | 295,924.0 | | | | | 1 | 295,924.0 | | | | |
| | **1** | **295,924.0** | | | | | **1** | **295,924.0** | | | | |

### 6.2 *Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл*

*/мянган төгрөгөөр/*

| **Алдаа, зөрчлийн товч утга** | **Нийт алдаа, зөрчлийн дүн** | | **Үүнээс: Төлбөрийн акт** | | **Үүнээс: Албан шаардлага** | | **Үүнээс: Зөвлөмж** | | **Үүнээс: Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн** | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** |
| 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 |
| Сүү хөтөлбөрийн хүрээнд хэмнэгдсэн зардлыг төсөвт төвлөрүүлээгүй | 1 | 640.3 | 1 | 640.3 | | | | | | |
| Ур чадварын нэмэгдлийг журам зөрчиж илүү олгосон | 1 | 9,383.5 | 1 | 9,383.5 | | | | | | |
| Хүлээж авсан сурах бичгийг дутуу бүртгэсэн, Түрээсийн сурах бичгийн тооцоо хийгээгүй, орлогыг төвлөрүүлээгүй | 1 | 2,495.6 | | | | | 1 | 2,495.6 | | |
| Газрын нэгдсэн сангийн системд бүртгэлтэй 8408000802 нэгж талбарын дугаар бүхий 1000 м2 газрыг 15 жилийн хугацаатай эзэмшүүлэхээр олгогдож газар эзэмшүүлэх гэрээ хийгдсэн ч газрыг үнэлж данс бүртгэлд тусгаагүй | 1 | 0 | | | | | 1 | 0 | | |
| | **4** | **12,519.4** | **2** | **10,023.8** | | | **2** | **2,495.6** | | |